

Тахийн Мэдээ

ГОВИЙН ИХ ДАРХАН ЦААЗАТ ГАЗАР "Б"
GREAT GOBI "B" SPA



ITG INTERNATIONAL TAKHI-GROUP

№ 20/ 2023 оны 11-р сар

Шинэ сорилт



2022/2023 онд цочир хүйтэрсэн нь их ган гачигийн дараа тахинд хүнд цохилт болов. Эрс тэс цаг агаар бол олон аюул заналын зөвхөн нэг нь. Үүний эсрэг ямар стратеги тус болох вэ?

Зургийг: Маркус Салате

Зэрлэг адууны өвөг, түүний хүрээлэн буй орчныг хамгаалцгаая.

Зэрлэг адууны хүндэт анд найз нараа,



Бид хэтэрхий өдрөгөөр харжээ. Харамсалтай нь 2022 оны гангийн дараа зөвхөн зуд (хахир хүйтэн өвөл) болоод өнгөрсөнгүй. Говийн их дархан цаазат газрын Б хэсэгт зэрлэг адуу энэ оны дөрөвдүгээр сард хорогдсоноосоо ч илүү хүнд цохилт амслаа. Сүүлийн тооцоогоор хорогдсон тахийн тоо 40

бус түүнээс 4.5 дахин их буюу 180 орчим болоод байна. Дөрөвдүгээр сард 100 орчим тахь алга болсонд тооцогдож байсан. Өнөөдрийн байдлаар тэд үрэгдэж үгүй болсныг бид мэднэ. Зуданд нэрвэгдэгсэд өвлийн сүүлээр даарч, өвс тэжээлгүй болж ядарч сульдах нь элбэг. Өнгөрсөн хатуу өвөл, 2009/2010 оныхтой адил хохирол их учрууллаа. Энэ удаад бид дархан цаазат газарт хавар байсан тахийн 26 орчим хувийг алдсан. Ялангуяа унага их нэрвэгдлээ. Гантай байсны уршгаар ердөө 23 унага төрснөөс өнөөг хүртэл дөрөв нь л амьд үлджээ.

Энэ бүхэн манай сэргээн нутагшуулах хөтөлбөрийг эрсдэлд оруулах уу? Өмнөх туршлагаар баримжаалах боломжгүй юм. 2009/2010 оны зудын дараах 6 жилийн дотор тахийн тоо толгой өсч сүрэг нөхөгдсөн. Харин өнөөдөр тэр зудын дараа үлдсэнээс хоёр дахин их тахь байгаа боловч тайвшрах аргагүй билээ. Говьд ган гачиг болсоор байна. Ахиад л хатуу өвөл болж тахь нэрвэгдэх магадлалтай. Эрс тэс уур амьсгал, бэлчээрийн даац хэтрэлт (бусад малтай бэлчээр хуваалцах), халдварт өвчин, гэрийн адуутай эрлийзжих зэрэг нь тоо толгойн тогтвортой байдалд байнга

заналхийлж байна. Бид үүнд шийдэл олох хэрэгтэй. Уур амьсгалын өөрчлөлтийн энэ үед дараагийн зуд хэзээ болохыг хэн мэдэх билээ?

Өөр нэг бэрхшээл бол байгаль хамгаалагчид өмнөх шигээ тахийг нэг бүрчлэн хянах боломжгүй боллоо. Тахийг сүргээр нь шууд ялгах боломжгүй болсон тул асар уудам хамгаалалттай газар нутаг дахь тахийн тоо толгойг найдвартай, нарийн тоолох аргагүй болж байна. Иймд өнөөдөр ГИДЦГ Б-д яг хэдэн тахь байгааг бид мэдэж чадахгүй байна. Тоо толгой тогтвортой өсч байгаа тул бид ойрын ирээдүйд нэрээр нь мэдэх нэгж бодгалийг хянахаас илүүтэйгээр сүргийн мониторингруу шилжихээр төлөвлөсөн. Энэ өөрчлөлтийг хийх цаг ийнхүү 2022/2023 оны зудтай давхацлаа.

Дүгнэлт: Дархан цаазат газар дахь тахийн тоо толгой 2022 оны хавар 349 байсан бол дараа хавар нь 257 болж, ганцхан өвлийн эрс хүйтэнд нийт тоо толгой 26 орчим хувиар буурсан байна. Олон жилийн амжилтын дараах огцом уналт. Говийн их дархан цаазат газрын Б хэсэгт тахь эрсдэлтэй нөхцөл байдлаас хараахан гараагүй байна. Тэдэнд Евразийн тал нутагт тэсч үлдсэн сүүлчийн зэрлэг адууны төлөө санаа тавих үнэнч байгаль хамгаалагчдын дэмжлэг хэрэгтэй хэвээр байна. Та өөрийгөө тэдний нэг гэж тооцдог уу?


ОУТГ-ийн Ерөнхийлөгч, доктор Рейнхард Шнидриг

2022 оны арванхоёрдугаар сарын 21-нд
Бөхөн азарганы сүрэг
Зургийг: С.Далайцэрэн

Өнгөрөгч хахир өвөл 2009/2010 оныхтой адил хүнд байлаа.

Говийн их дархан цаазат газрын Б хэсэг дэх тахийн тоо толгой

1992-2023



Сэрэмжлэн хамгаалах нь

Зэрлэг адууны өвгийг хамгийн сүүлд үлдээд байсан газарт нь сэргээн нутагшуулснаар төрөл зүйлийг хамгаалахын тухайд жинхэнэ амжилт болсон нь дамжиггүй. Онгон байгальд устаж үгүй болсон нэгэн зүйл том зэрлэг амьтныг барьж авчирсан, 30 жилийн турш байгальд дахин нутагшуулж, амжилттай үржүүлж, байгальд өсөн үржиж буй популяцийг бий болгож чадсан. Амьтны хүрээлэнгийн тахь зэрлэг байгальд амьдрах чадваргүй, амьдрах орчин нь амаргүй, бэрхшээлтэй байсан ч амжилтанд хүрчээ. Тэртээх 30 орчим жилийн өмнө энэхүү онцгой үүргийг хүлээсэн цөөн хэдэн алсын хараатай, ивээн тэтгэгчид, мэргэжлийн хүмүүс аз сорин байж ийм гайхалтай амжилт авчирсных нь төлөө бид талархах ёстой.

Сэргэн нутагшихаас устаж үгүй болох нь хамаагүй хурдан. Зоригтой алхам бидний төсөөлөөгүй бэрхшээлээр дүүрэн байлаа. Заримдаа түр зогсож урт амьсгаа авах ч хэрэг гарна. Өнгөрсөн хахир өвөл үүний жишээ юм. 2020 оны 10-р сарын дундуур байгаль хамгаалагчид дархан цаазат газарт 320 тахь тоолж, 2021 оны тавдугаар сард 300 дахь унага төрсөн. Өнгөрсөн намар ГИДЦГ Б-гийн зэрлэг адууны тоо бүр 400 гаруй болж өссөн бол хэдхэн сарын дараа Монголын баруун, өмнөд хэсгээр тохиолдсон цаг агаарын ганц л үзэгдлийн улмаас олонх нь үхсэн.

Цаг агаарын ийм эрс тэс үзэгдэл Монголын зэрлэгшсэн тахийн сүргийг бүхэлд нь устгаж болзошгүй юм.

Гэхдээ энэ бол цорын ганц томоохон эрсдэл биш билээ. Ган гачиг, бог мал, адууны бэлчээрийн өрсөлдөөн, малаас халдварладаг халдварт өвчин зэрэгт анхаарал хандуулах хэрэгтэй. Эрсдэл үүгээр зогсохгүй. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр Говийн цөлөрхөг хэсэгт ойр ойрхон ган гачиг болж байгаагийн зэрэгцээ мал сүргийн тоо толгой хурдацтай өсч нэгэнт ихээхэн сийрэг болсон ургамлын сэргэлтэд аюул учруулан эрсдэлийг улам хурцатгаж байна.

Дахин нутагшуулсан популяци хэдхэн зуугаар тоологдож байгаа үед дээрх эрсдэл бүхэн аюултай. Хэрэв бид зэрлэг адууны өвөг-Тахийг хойч үедээ үлдээхийг хүсч байвал цаг үргэлж сэрэмжтэй байж, сөрөг стратегиар зэвсэглэх ёстой. Тал хээрийн өөр бүс нутгуудад тахийн хэд хэдэн бие даасан популяци бий болох хүртэл мөстлөгийн үеийн энэхүү өвийг аварсан гэж үзэх боломжгүй юм. Сэргээн нутагшуулсан нь төрөл зүйлийг аварсан гэхээсээ илүү гайхалтай амжилт болсон. Гэхдээ амьтны хүрээлэнгийн Тахийн удмын багахан сан, урт хугацаандаа цөөдөхөөр тооны нөөцийг баталгаажуулахын тулд бид үргэлж анхааран бэлтгэх ёстой.

Хэрэв бид өвөг зэрлэг адууг хойч үедээ үлдээхийг хүсвэл үргэлж сэрэмжтэй байж, эрсдэлийг сөрж хамгаалах стратегиар зэвсэглэх ёстой.

Зөв чиглэл: Кристиан Стауффертай хийсэн ярилцлага

«Зэрлэг адууны нөхөд»-ийн ерөнхийлөгч, ОУТГ-ийн дэд ерөнхийлөгч Кристиан Стауфферын танилцуулга

Кристиан Стауффер бол Цюрихийн их сургуулийг төгссөн, ашгийн бус байгууллагуудын менежментийн чиглэлээр Бизнесийн Удирдлагын Магистр зэрэгтэй, зэрлэг ан амьтдын биологич юм. Монгол улсад зэрлэг адуу нутагшуулах үйлсэд анхны бөгөөд гол хувь нэмэр оруулсан хүмүүсийн нэг. Тэрээр Европын үржлийн хөтөлбөрт хамрагдаад байсан Лангенбергийн зэрлэг амьтдын тусгай хамгаалалттай газрын захирлаар ажиллаж байхдаа Монгол руу онгоцоор тахь тээвэрлэх аргыг боловсруулан, Говийн их дархан цаазат газрын Б хэсэгт анхны зэрлэг тахийн сүрэг бий болгоход ашигласан. 2013 онд Стауффер Швейцарийн Тусгай Хамгаалалттай Газруудын сүлжээний захирал, 2020 онд Махчин амьтдын экологи, зэрлэг ан амьтдын менежментийн KORA сангийн захирал болсон. Кристиан Стауффер 2015 оноос хойш ОУТГ-ийн дэд ерөнхийлөгч, 2000 оноос хойш «Зэрлэг адууны нөхөд» байгууллагын ерөнхийлөгчөөр ажиллаж байна.



Говьд тахь сэргээн нутагшуулах нь дараах хүчин зүйлүүдээр тодорхойлогдох ба үүнтэй ижил болон өөр хэлбэрээр нутагшуулах, эсвэл бусад амьтны төрөл зүйлд ч мөн хамаарна.

Эдгээр амьтдыг барьж, 100 жил хүний гараар тэжээн, амьтны хүрээлэнд үржүүлжээ. Нэг талаар бид тахийн дасан зохицох чадварыг гайхаж байгаа бөгөөд нөгөө талаар, тэдэнд ажиглагддаг хашир болгоомжтой зан чанар зэрэг нь тэдний түүхтэй холбоотой эсэхийг хэлж мэдэхгүй байна.

Бүх тахь 12 үндсэн тахиас гаралтай тул анхны популяци, генетикийн олон янз байдлын маш бага хэсгийг төлөөлдөг. Олон шинж чанар алдагдсан байх магадлалтай. Хэрэв амьтад одоо байгалийн шалгаралд дахин өртөх юм бол энэ шалгарал маш хязгаарлагдмал сонголтын хүрээнд явагдах болно.

Говийн их дархан цаазат газрын Б хэсэг нь адууны бэлчээрийн зах хязгаарт, уур амьсгал, ургамлын хувьд хамгийн тохиромжтой бүсээс хол байрладаг. Тиймээс ямар нэгэн өөрчлөлтөд маш мэдрэмтгий, хүчтэй харцу үйлдэл үзүүлэх магадлалтай. Мөн нутаг дэвсгэр, холбоо хамаарлын хувьд сэргээн нутагшуулах шаардлагыг хангасан Монгол Улс дахь ганц газар юм.

Дахин нутагшуулах нь байгалийн шалгарлыг хүлээн зөвшөөрөх, популяцийг хадгалан хамгаалах хоёрын тэнцвэрийг хангах үйлдэл юм. Махчин амьтан, уур амьсгал, хоол хүнс зэрэг байгалийн хүчин зүйлсийг хүлээн зөвшөөрөх ёстой, гэхдээ дасгах болон тээвэрлэлтийн нөлөөллөөс аль болох хол байлгах хэрэгтэй. Тахийн маш хашир болгоомжтой зан авир нь онцгой сорилт болдог. Говь нутагт байршлаас хамаарч харилцан адилгүй хур тунадас ордог. Зэрлэг амьтад нүүдэллэх замаар илүү сайн өвс олж чадна. Харин Тахь үүнийг 30 жил өнгөрсний дараа ч маш хязгаарлагдмал хэмжээгээр хийж байна.

ОУТГ: Говийн их дархан цаазат газрын Б хэсэгт зэрлэг адууны тоо толгой өнгөрсөн өвлийн хүйтэнд 180-аад толгойгоор эрс буурчээ. Эдгээр тахийн хорогдсон шалтгаан болон бусад тахийн амьд үлдсэн учир юу вэ?

К.Стауффер: 2022/23 оны өвөл хар зуд гэгчийг даван туулах хэрэгтэй болсон. Зун нь маш хуурай, тачир өвстэй, дараа нь цас багатай хүйтэн өвөл боллоо. Олон тахь, ялангуяа унага, хөгшин амьтад өвлийг ядруухан угтсан. Тэднээс олонхи нь өвлийг давж чадаагүй, нилээд нь шимэгч хорхойнд бариулсан байсан. (7-р хуудаснаас уншина уу).

ОУТГ: Энэ дархан цаазат газар бас Хулан (Азийн хулан) болон цагаан зээр нутаглах хамгийн чухал газрын нэг. Эдгээр амьтад мөн их хэмжээний хохирол амссан уу, эсвэл цаг агаарын эрс тэс уур амьсгалыг харьцангуй сайн даван туулж байна уу?

К.Стауффер: Эдгээр хоёр төрөл зүйл амьтад хуурай нөхцөлд зэрлэг адуунаас илүү сайн зохицдог. Ялангуяа хулан нүүдлийн зан төлөвтэй бөгөөд үүний ачаар тэд илүү сайн нөхцөл бүхий газар нутгийг хайж чадна.

ОУТГ: Яаралтай өвсөөр хангасан бол бүх тахь амьд үлдэх байсан болов уу?

К.Стауффер: Би тэгж бодож байна. 2022/23 оны өвлийн улиралд Тахийг хэтэрхий оройтож тэжээсэн тул харьцангуй бага үр дүн өгсөн байж магад. Ийм өргөн уудам нутагт ингэж муу ургамалтай байхыг хэзээ ч хараагүй. Ийм үед бид эрт өвс өгч эхлэх ёстой байсан. Энэ бас бидний өнгөрсөн өвлөөс сурсан хамгийн чухал зүйл боллоо.

“2022 оны зун хэт хуурайшиж сийрэг тачир өвс ургасан, дараа өвөл нь цас багатай хүйтэн байлаа.”

Зөв чиглэл: Кристиан Стауффертай хийсэн ярилцлага

ОУТГ: Энэ бол 30 жилийн өмнө тахь нутагшуулж эхэлснээс хойш гурав дахь зуд юм. Ойролцоогоор 10 жил тутамд эрс тэс өвөл болох төлөв харагдаж байна. Асар их зардал гаргаж энд нутагшуулсан тахийн популяци ийм шалтгаанаар амархан арчигдаж болох юм. Яагаад зудын аюулыг эрт зарлан мэдээлж алдагдлыг бууруулах боломжгүй байна вэ?

К.Стауффер: Зуд болгон адилгүй. Нэгд нь агаарын хэм эрс өөрчлөгдөж байхад, нөгөөд нь их хэмжээний цастай (өмнөх зун нь хэвийн хэмжээний хур тунадас орсон), харин 22/23 оны зудын өмнөх зун гандуу хуурай байсны уршгаар их хэмжээний газарт ямар ч ургамал ургах боломжгүй байв. Энэ жил зуд болж болзошгүй гэсэн дохио мэдээллийг анхааралдаа авч чадсангүй.

Нэмж хэлэхэд, 2010 оноос хойш ерөнхийдөө байдал сайжирч байсан. Бид нэлээд хэдэн жил ахиу хадлан бэлдсэн ч ашиглаагүй. 12 жил өнгөрөхөд сонор сэрэмж бага зэрэг буурч, бусад асуудалд чиглэв.

ОУТГ: Зудын үед стратегийн ач холбогдол бүхий ил задгай өвсөн бухал, хаацайлах мод бут нь амьд үлдэх боломжийг ихээхэн нэмэгдүүлнэ. Хятадын говьд салхи, элэгдэл, цөлжилтөөс хамгаалах зорилгоор заган бут сөөг (нэн ховордсон унаган зүйл) ургуулан ойжуулж байна. Мөн цаг агаарын нөлөөнөөс хамгаалах өвсөн бухалыг Европт олон мянган жилийн турш ашиглаж ирсэн. Энэ талаар бодож үзсэн үү?

К.Стауффер: Тахь хүнээс хараат бус, чөлөөтэй тархан нутагших нь бидний гол зорилго юм. Говийн загийг хамгаалах, ургуулах асуудал ч бас чухал асуудал, түүнийг илүү эрчимтэй хамгаалах арга хэмжээ авах байтал бид авч үзээгүй.

ОУТГ: Шим мандлын нөөц газарт малын тоо толгой, тухайлбал, ноолуурын чиглэлийн ямаа, гэрийн адууны тоо байнга нэмэгдэж байна. Үүнтэй холбоотойгоор, хоол хүнс, бэлчээрийн даац хэтрэх, халдварт өвчин тархах, (морины хувьд) эрлийзжих зэргээр зэрлэг адуунд гурав дахин том эрсдэл учирдаг. Ийм эмзэг экосистемийг улам бүр эрчимтэй ашиглах болсон нь ховордсон том хөхтөн амьтдыг хамгаалах асуудалд хэрхэн нийцэж байна вэ, ОУТГ эдгээр эрсдлийг хянахын тулд ямар ажил хийж байна?

К.Стауффер: Малын тоо толгой өсөх нь асуудал болоод байна. Ноолуурын хувьд бид ямааны тоо толгойг хязгаарлахын зэрэгцээ үнэ цэнийг нэмэгдүүлэхэд шууд чиглэн ажиллаж байна. Гэрийн адууны тоо толгой нэмэгдэж байгаа нь одоог хүртэл оньсого хэвээр бөгөөд гэрийн адуу эдийн засгийн хувьд ямар ч үнэ цэнэгүй, аж ахуйд бараг ашиглагддаггүй. Энэхүү асуудлаар бид ирэх жилүүдэд хүчин чармайлтаа нэмэгдүүлж ажиллах шаардлагатай байна.



*Тал хээр эцэс төгсгөлгүй үргэлжилнэ. Гэвч эргэшгүй эвдрэлээс зайлсхийхийн тулд сийрэг ургамлыг маш болгоомжтой ашиглах хэрэгтэй.
Зургийг: С.Далайцэрэн*

“Бидний зорилго бол хүнээс ангид, чөлөөтэй тархсан тахийн популяци юм.”

Салатэгийн гэр бүл (арын эгнээний 2.-4.-рт) аялалын хөтчийн халт (арын эгнээний 1, 3, 4.-рт)
Зургийг © Маркус Салатэ



ОУТГ: Нүүдэлчид болон тэдний мал сүрэг усалгааны чухал цооног, бэлчээрт нэвтрэхгүй болсон. Харин хараа хяналтгүй гэрийн адууг хорьж хязгаарлах аргагүй. Энэ асуудал мөн үү?

К.Стауффер: Тийм ээ, энэ бол асуудал. Харин бид шалтгааныг мэдэхгүй шахам хэвээр л байна. Тиймээс бидэнд эсрэг арга хэмжээ авах үндэслэл хараахан алга.

ОУТГ: Өнгөрсөн зуднаар өмнө нь хийж байсан тахийн нэгж бодгалийн хяналт хязгаартаа хүрсэн. Тоо толгойн хяналтад шилжсэний дараа мэдээлэл найдвартай хэвээр байх уу?

К.Стауффер: Бодгалийн хяналт нь дархан цаазат газрын дарга асан Ганбаатарын ур чадвар, бас хобби байсан. Үүнийг үргэлжлүүлж чадахгүй байгаа нь түүний явсантай болон тахийн тоо толгойн өсөлт, хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбоотой. Гэсэн ч тоо толгойгоор бүртгээд явахад найдвартай мэдээлэл цуглуулах боломжтой гэж би харж байна. Энэхүү мэдээлэл хангалттай.

ОУТГ: ОУТГ, эсвэл Дархан цаазат газрын удирдлага Говийн их дархан цаазат газрын Б хэсэг дэх тахийн популяцийг урт хугацаанд хадгалан хамгаалахын тулд тэргүүлэх чиглэлээ өөрчлөх шаардлага байгаа юу?

К.Стауффер: Хамгийн их санаа зовоож буй зүйл бол уур амьсгалын өөрчлөлт бөгөөд бидэнд үүнтэй тэмцэх хөшүүрэг төдийлөн байхгүй. Монгол орон даяар ган гачиг нэмэгдэж байна. Говьд гарч буй өөрчлөлтийг авч үзэхдээ ус судлалын асуудалд анхаарлаа хандуулах нь зайлшгүй. Эндхийн заг зэрэг ургамлууд уур амьсгалын тогтвортой байдалд ихээхэн хувь нэмэр оруулдаг тул үүнийг сайтар анхаарах ёстой гэж харж байна.

“Говийн уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхдээ ус судлалд анхаарал хандуулах нь зайлшгүй”

Тахь хорогдох шалтгаан

Швейцарийн малын эмч, адууны мэргэжилтэн, доктор Анжела Бексек энэ хавар Их говийн Б дархан цаазат газарт зуднаар хорогдсон тахийн үхлийн шалтгааныг судалжээ. Тэдний олонх нь хэдгэнийн (botfly) халдварт өртөж хүндэрсэн нь тогтоогдсон. Гэрийн адууны гэдсэнд амьдардаг хэдгэнийн авгалдай нь шархлаа, колик, хоолны дуршилгүй болох, гүйлгэх, тураал, цус багадалт үүсгэж архаг гастритаар өвчлүүлдэг. Ялангуяа унаганы өсөлт хөгжил доголдож, чадал тэнхээ доройтон биеийн эсэргүүцэл буурдаг. Хэд хэдэн судалгаагаар ердийн үед зэрлэг тахийн ходоод гэдсэнд шимэгч хорхой байдаг нь тогтоогдсон ч хэдэн долоо хоногоор хүйтэрдэг зудын үед тухайн амьтныг доройтуулах боломжтой.

30 шахам үхсэн тахиас, Улаанбаатар дахь Их Сургуулийн Мал эмнэлгийн хүрээлэнгийн тусламжтайгаар дээж авчээ. Эдгээрийг одоогоор Монголын их сургуульд шинжилж байна. Үхсэн бүх амьтад эцэж турсан байсан нь тогтоогдсон. Амьтны титэм судасны өөх хүртэл эрчим хүчний дутагдалд орсон биеийн өөх тосны сүүлчийн эх үүсвэр болж хатингаршжээ. Доктор Бексекийн хэлснээр, үнээн дээр ажиглагддаг «өвлийн тураал»-тай төстэй дүр зураг ажиглагджээ. Зуны дулаантай харьцуулахад өвлийн тэсгим хүйтэн өлдсөн амьтдыг хавсран нэрвэх тул өвлийн улиралд үхэх магадлал өндөр байдаг. Нэмээд ядарч сульдах, шимэгч хорхойн халдвараар өвчлөх нь амьтдыг улам сулруулж, улмаар эрт үхэхэд хүргэдэг.

Үхсэн тахийн насны ангиллаас харахад төл (1-4 нас хүртэл) болон хөгшин тахь ихэвчлэн үхжээ. Ихэнх сэг зэмийг тахь өвөлждөг газар, тухайлбал жилийн турш цэвэр устай байдаг Тахийн ус, Хонин ус баян бүрдээс олжээ. Ерөнхийд нь харахад тахь ердөө л өлсөж үхсэн байна. Бүх тахинд яаралтайгаар өвс тавьж өгсөн ч энэ нь хүрэлцээгүй байсан.



*Доктор Анжела Бексек Тахийн талд угжаар өссөн өнчин тахь Батаатай хамт.
Зургийг: С.Далайцэрэн, © А.Бексек*

Доктор Бексек ажлынхаа явцад гэрийн малын эрүүл мэнд ч маш дорой байдалд байгааг анзаарчээ. Бараг “яс, арьс» болсон байв. Доктор Бексек экосистемийг хамгаалах асуудал нь зэрлэг амьтдын эрүүл мэнд болон, тэдэнтэй шим мандлын нөөцийг хуваалцдаг гэрийн мал, туурайтан амьтдын эрүүл мэндийг мөн багтаадаг гэдгийг тодорхой хэлсэн. Говь нутагт сүрьеэ, паразит, шимэгч хорхой, бабезиоз зэрэг архаг өвчтэй гэрийн тэжээмэл мал, хоол тэжээлийн дутагдалтай хавсарч «цагтай тэсрэх бөмбөг» болж байгааг доктор Бексек санууллаа. Тэрээр мал, гэрийн адууны эрүүл мэндийг дорвитой сайжруулах зайлшгүй шаардлагатай гэж үзсэн бөгөөд ингэснээр ховордсон зэрлэг амьтад шууд бусаар ашиг тус хүртэх болно. Үүний тулд Говийн их дархан цаазат газрын Б хэсгийн мал сүргийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлж (төрийн дэмжлэгтэйгээр), арчилгаа (вакцинжуулалт, туулгалт) болон тогтмол хяналт шалгалт хийх ёстой. Энэ нь зэрлэг туурайтан амьтдыг халдварт өвчнөөс хамгаалах наад захын арга хэмжээ болно. Цаашилбал, нөөц газарт байгаа гэрийн адуу хяналтгүй үржсээр байгаа тохиолдолд тахийн генийн шинжилгээг тогтмол хийж эрлийзжилтийг илрүүлэх шаардлагатай. Эцэст нь зэрлэг болон тэжээвэр амьтдын мэдээллийг цуглуулж нэгтгэн тайлагнаж, үхэл хорогдолд зөв дүн шинжилгээ хийх найдвартай систем хэрэгтэй.



“ Экосистемд зэрэгцэн орших зэрлэг болон гэрийн тэжээвэр туурайтан амьтдын эрүүл мэндийг хамгаалах нь экосистемийг хамгаалах ажлын нэгээхэн хэсэг юм.”

Цаашдын зорилго: 2024 оны төлөвлөгөө

2022/2023 оны зуд бидэнд хатуухан уналт боллоо. Гэвч хээр тал хэн хүний харааг тэлнэ. Алсдаа бид дэлхийн хамгийн уудам, хамгийн чухал тал хээрийн байгаль орчныг тэнд амьдарч буй хүмүүсийн төлөө, тэдний хамтаар үргэлжлүүлэн хамгаалахыг хүсч байна. Үүнд бид дараахь арга замаар хүрэх болно:

- Экосистемийг хянах, хамгаалах, холбоо хамаарлаар нь авч үзэх, мөн нүүдэлчин хүн амын тогтвортой хэрэглээг зохистой хангах.
- Бие даах чадвартай тахийн тоо толгой бий болгох
- Хүн амын дунд байгаль хамгаалах үзэл санааг бэхжүүлэх (Алтай, Тахийн тал дахь төвүүдийн үйл ажиллагаа, мөн «Говийн өргөө»-ний үзэсгэлэн, үйл ажиллагааны концепци зэрэг)
- Ерөнхий хөтөлбөрийн мэргэжлийн удирдлага

Дээр дурдсан зорилтууд нь олон тооны бие даасан үйл ажиллагаагаар хэрэгжих бөгөөд ОУТГ тэдгээрийг дэмжих санхүүжилт хайдаг. Тухайлбал, ноолуурын өртгийн тогтвортой сүлжээ, аялал жуулчлалд шаардлагатай сургалтын хөтөлбөр, дэд бүтцийг бий болгох; мөн биологийн олон янз байдлын тооллого, тал хээрийн туурайтан амьтад, чухал ач холбогдолтой амьдрах орчныг хянах, ус хуримтлуулагч загийн бутыг нөхөн сэргээх, ирээдүйн зэрлэг амьтдын коридорын үндсэн шугамыг боловсруулах зэрэг багтана.

Үндсэн даалгавар бол тахийн популяцийг хянах, энэхүү ховордсон зэрлэг амьтны эрүүл мэнд, эрлийзжилтийг харж хамгаалах явдал юм.

Мөн «Говийн өргөө»-ний мэдээллийн ажлууд, орон нутгийн засаг захиргаа, нүүдэлчид болон бусад тусгай хамгаалалттай газар (холбогдох нөөц газрууд)-тай хамтран ажилласнаар байгаль хамгаалах арга хэмжээний ач холбогдлыг орон нутгийн иргэдэд ойлгуулах болно.

Эдгээр үйл ажиллагаанд байгалиа хайрлан хамгаалагч, дэмжигчдийн төслийн хандив зайлшгүй хэрэгцээтэй байдаг юм. Бид жил бүрийн хурлаараа өмнөх жилийн хандивын зарцуулалтын тайланг танилцуулдаг билээ.

Ховд аймгийн Алтай сумд баригдах Хамгаалалтын Захиргааны байр

Хамгаалалтын Захиргааны байрны талаар сайхан мэдээтэй. Энэхүү хамгаалалтын захиргаа, мэдээллийн төв нь ДЦГ-ын үйл ажиллагааны ажлын нөхцөлийг сайжруулж, мэргэшсэн ажилчид болон тэдний гэр бүлийн хүмүүсийн ажиллах урам зоригийг ихээхэн нэмэгдүүлэх болно. Манай үнэнч дэмжигчдийн хандив, KfW (Kreditanstalt für Wiederaufbau)-аас авсан төслийн зээлийн ачаар ирэх онд барилгын ажил эхлэх боломж бүрдсэн ба 2025 онд дуусгахаар төлөвлөж байна.

Зэрлэг адууны нөхөд аян замд

Энэ жил Швейцарийн тахийн үнэнч дэмжигчид (Салате, Зигфрид, Витциг нарын гэр бүл) Монголд адал явдалтай аялж амарлаа. Тэд аялалаас сэтгэл өндөр ирсэн ба тэдэн шиг цөлийн эко (эко-сафари) аялал зохион байгуулахыг уриалав. “Тахийн мэдээ”-д хэвлэх энэ сайхан зургуудыг өгсөнд, бас мэдээж хандив өгсөн Та бүхэнд маш их баярлалаа!

ОУТГ-ийн Ерөнхийлөгч Доктор Рейнхард Шнидриг, ОУТГ-ийн Удирдах зөвлөлийн гишүүн Карин Хинденланг нар мөн энэ зун Монгол Улсад төслийн хүрээнд өргөтгөсөн айлчлал хийсэн. Энэ үеэр Шнидриг, Биж багт (Говь-Алтай, Бугат сум) Монголын үндэсний их баяр наадмыг (7-р сарын 11-12) тэмдэглэхэд ивээн тэтгэгчээр ажиллалаа. Баяр наадамд олон зочид, наадамчид хүрэлцэн ирж бөх барилдаж, сур харваж, морь уралдуулан наадлаа.



Говийн тансаг үдийн хоол.
Зургийг: © Маркус Салате

Цуутыг алдав

2015 оны аравдугаар сард олдсон өнчин унагыг тахийн гүүнд авахуулж өсгөөд, шүдлэн насанд нь Тахийн ус баянбүрдэд эх нь болох гүүтэй хамт тавьсан тухай, тэрхүү унага “Цуут” нэртэй азарга болсон тухай бид 8 жилийн турш уншигчдадаа удаа дараа мэдээлж байсан билээ. Тэнд тэр хурдан бойжиж, нутгийн азарганы сүргээс хөөгдсөн боловч зоригтойгоор тэмцэлдэж, өрсөлдөгчөө богино хугацаанд хөөн зайлуулсан. Дараа нь тэрээр хурдан өсөж, сүргийн хамгийн хүчирхэг азарганы нэг болсон билээ. Харин энэ хаврын хүйтэнд хээрийн олон амьтдад учирсан тавилан түүнийг ч бас тойрсонгүй. Цуут маань 2022/2023 оны хатуу өвлөөр хорогдсон 180 орчим тахийн нэг болов.



ГИДЦГ Б хэсэг С.Далайцэрэн

Тоо толгойн хяналт: Өгөгдөл хэрхэн өөрчлөгддөг вэ?

Зэрлэг ан амьтдын биологич Ганбаатар, Далайцэрэн нар өнгөрсөн зуныг хүртэл өвөг зэрлэг адууны сүрэг бүрийг төдийгүй нийт 300 гаруй тахийг бараг нэг бүрчлэн нэрлэн таньж байсан. Тоо толгойг ийм нарийн ялгаж мэдэхэд бүл сүргийн тогтвортой байдал нөлөөлсөн. Гэвч өнгөрсөн өвлийн зуд хүртэл унага олноор төрж хүйсийн харьцаа улам бүр тэнцвэржин сүргийн динамик нэмэгдэж, тоо толгой хурдацтай өссөн нь энэ аргын хэрэглээг хязгаарлахад хүргэлээ. Улмаар Ганбаатар, Далайцэрэн нарыг шилжин явсны дараа тахийн тоо толгойн судалгааг бодгалийн хяналтаас нийт тоо толгойн хяналт болгон өөрчлөх зайлшгүй шаардлага тулгарсан. Энэ нь эх сүргийн бие даасан бүлгийн динамикаас нийт популяцийн экологид илүү их анхаарал хандуулах боломжийг олгож байна.

Гэхдээ ганц тахь бүү хэл бүтэн сүргийг олж тогтооход бэрхшээлтэй болсон үед ямар аргаар хамгийн чанартай мэдээлэл авах вэ? Бид хяналтын зорилгыг хэрхэн чиглүүлэх, мөн сүргийн чиг хандлагыг хэрхэн алдалгүй хянах вэ? Биологийн ангийн оюутан Анхзаяа, 2023 оны 9-р сараас эхлэн МУИС-ийн магистрын хөтөлбөрт ОУТГ-ийн санхүүжилтээр хамрагдахдаа эдгээр асуудлуудыг судлах болно.

Тахийн сүрэг, 2023.08.15
Зургийг: © Маркус Салате



Тахийн популяцийн судалгааг бодгалиас тоо толгойн хяналтад шилжүүлснээр тоо толгойн экологид анхаарлаа төвлөрүүлж байна.

Зүйлийн хөрөг: Эрээн хүрнэ^{1,2}



Зургийг ©zoofanatic, <https://www.flickr.com/photos/zoofanatic/18277723408>

Эрээн хүрнэ (*Vormela peregusna*) маш хөөрхөн зүстэй. Яг л бяцхан бар, өмхий хүрэн хоёрыг нийлүүлсэн мэт харагддаг содон амьтан.

Шавьжнаас эхлээд эмгэн хумс, хоёр нутагтан, мөлхөгчид, шувууд зэрэг туулай хүртэлх хэмжээний бүх төрлийн хөхтөн амьтад энэхүү богино хөлтэй, ер бусын том чихтэй, үен шиг шаламгай, багтай мэт амьтанаас болгоомжилно. Энэ амьтан манай Өмхий хүрний нэг зүйл (*Mustela putorius*) болон Өмхий хүрнэ (*Mustela eversmanii*) хоёртой нилээд төстэй ч гэлээ Суусрын овгийн төрөл зүйлийн өөр дэд овогт багтдаг. Уг дэд овогт дэлхий даяар зөвхөн 6 зүйлийн амьтан хамаардаг. Эртний 4 төрөл зүйлийн нэг болох энэхүү амьтны тод судал нь Эрээн хүрний өөрийгөө хамгаалах гэж шулуун гэдэсний булчирхайгаараа ялгаруулдаг маш муухай үнэртэй шүүрлийг махчин амьтдад сануулдаг.

Эрээн хүрнэ бол энэ онцгой бүлгийн Евразид байгаа цорын ганц төлөөлөгч юм. Уг амьтан Балкан, Левантаас (Арабын хойгийг эс тооцвол) зүүн Хятад хүртэлх тал хээр, цөлийн бүсэд нутаглана. Далайн түвшнээс 2000 метрээс дээш өндөр уулсаас зайлсхийж, хуурай хөндий, бутлаг газар, манхан, заган бутлаг, шаварлаг тал, баян бүрдэд амьдардаг.

Эрээн хүрнүүд ихэвчлэн харанхуй бүрэнхий болон шөнийн цагаар идэвхитэй. Өдрийн цагаар тэд голдуу том үлийн цагаан оготноос булааж авсан, өвс навч дэвссэн нүхэндээ амарч байдаг.

Гэхдээ бас хурц хумстай урд сарвуугаараа өөртөө нүх ухаж чадна. Шөнийн цагаар газар дээр болон доор, сайн авирагчийн хувиар модонд ч ан хийдэг.

Тэдний гол идэш тэжээл нь тухайн газрын мэрэгч амьтад юм. Израилд хийсэн судалгаагаар эрээн хүрний нутаг дэвсгэр нь 0.5 км² талбайг хамардаг. Энэ нь бусад бодгалийн нутаг дэвсгэртэй давхцаж болох боловч ганцаараа амьдардаг.

Орооны үе нь 3-р сараас 6-р сарын эхэн хүртэл үргэлжилнэ. 45 хоногийн дараа буюу эсвэл температурын нөлөөгөөр өндгөн эс хожуу тогтож дараагийн 2, 3-р сард (240-330 хоногийн дараа) 4-8 зулзаганууд төрдөг. Тэднийг зөвхөн эмэгчин нь өсгөж, 50 орчим хоногийн дараа хөхүүлдэг. 2 сар орчмын дараагаас тусдаа амьдарцгаана.

Эм нь 3 сартайдаа, эр нь 1 настайдаа бэлгийн бойжилт гүйцнэ. Нөхөн үржихүйн харьцангуй өндөр чадвартай тул олон төрлийн махчин, тухайлбал махчин шувууд зэрэг амьтдын хоол тэжээлийн хомсдолыг нөхдөг.

Гэсэн хэдий ч эрээн хүрнийн популяци 20-р зуунд хэсэгчлэн сүйрч, Дэлхийн Байгаль Хамгаалах холбооны (IUCN) Улаан жагсаалтын ховордсон ангилалд орсон нь тал хээр, цөлийн амьдрах орчин маш хурдан алдагдаж байгаатай холбоотой. Тэдний амьдрах орчныг хөдөө аж ахуйн газар болгон хувиргаж байгаагаас ялангуяа Европт олон жижиг мэрэгчдийн амьдрах орчин устаж байна. Мэрэгчдийг устгах хор, хавханд эрээн хүрнэ ч өртөх болжээ. Хятадад мөн энэ төрөл зүйл нь цөлжилтийн аюулд өртөж байна.

Эрээн хүрнэ бол тал хээрийн онцгой анхаарал татсан төрөл зүйл юм. Уг амьтан Бернийн конвенцийн II хавсралтын дагуу хатуу хамгаалалтад орсон бөгөөд тал хээрийн сүүлчийн амьдрах орчныг яаралтай хамгаалах шаардлагатайг анхааруулж байна. Монголд энэхүү амьтныг ховордсон гэж үздэг.³

Энэ зүйлийн талаарх бидний мэдлэг нэлээд хязгаарлагдмал. Бид популяцийн ангилал зүй, тархалт, хэмжээ, чиг хандлагын талаар нарийн мэдэхгүй бөгөөд тодорхой аюул заналхийлэл, зорилтот хамгаалалтын арга хэмжээний талаар ч мэдээлэлгүй байгаа юм. Үндэсний болон олон улсын менежментийн төлөвлөгөө, олон улсын худалдааны хяналт, орон нутгийн иргэдэд зориулсан мэдээлэл, боловсролын хөтөлбөр дутмаг байна. Одоогоор Европын амьтны хүрээлэнгүүдэд хамгаалах хөтөлбөрийг дөнгөж эхлүүлээд байна.

¹ Wilson DE, Mittermeier RA (2009): Handbook of the Mammals of the World, Vol. 1, Carnivores. Lynx Edicions, Barcelona

² Abramov, A.V., Kranz, A. & Maran, T. 2016. *Vormela peregusna*. The IUCN Red List of Threatened Species 2016: e.T29680A45203971. <https://dx.doi.org/10.2305/IUCN.UK.2016-1.RLTS.T29680A45203971.en>. Accessed on 04 October 2023.

³ Shagdarsuren, O., Jigi, S., Tsendjav, D., Dulamtseren, S., Bold, A., Munkhbayar, Kh., Dulmaa, A., Erdenejav, G., Olzihutag, N., Ligaa, U. and Sanchir, Ch. 1987. Mongolian Red Book. Publishing House of the Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia.

Эрээн хүрнэ, тал хээрийн сүүлчийн амьдрах орчныг хамгаалах зайлшгүй шаардлагатайг сануулж байна.

Бяцхан уриалан дуудагч

Эрээн хүрнэ нь Евразийн тал хээрийн өвөрмөц зүйл юм. Мөн тал нутаг шигээ аюулын ирмэгт ирсэн. Хөдөө орон нутгийн хүн амаар тогтохгүй биологичид ч энэ зүйлийн талаар муу мэддэг тул зорилтот хамгаалалтын арга хэмжээг тодорхойлоход бэрхшээлтэй. Одоогоор Европын амьтны хүрээлэнгүүдэд хамгаалах хөтөлбөрийг дөнгөж эхлүүлээд байна.

Эрээн хүрнийг хэзээ нэгэн цагт байгальд дахин нутагшуулах шаардлага гарахгүй гэж найдъя...



Улаан Хаданд авирч гарсны баяр
Зургийг: © Маркус Салате



Говийн Их дархан цаазат газрын “Б” хэсэгийн нутагт Монголын Зүүнгарын говийн 60 хувь нь хамгаалагдсан байна. 11

Зэрлэг адууны ирээдүйг хамтдаа бататгая



“Говийн их дархан цаазат газрын Б хэсэгт есдүгээр сарын сүүлчээр анхны цас орсон. Бид урьдчилан сэргийлж 156 тонн өвс авч бэлтгэнэ. Дахиад хатуу өвөл болвол Тахийг 12-р сараас 4-р сарын дунд хүртэл 4 сар тэжээх боломжтой байхыг зорьж байна. Энэ ажилд тусалж буй бүх хандивлагчиддаа маш их баярлалаа!”

Ребекка Блюмер, ОУТГ - ийн санхүүч

ОУТГ нь нэр хүндтэй ажил эрхэлдэг.

Хандив бүр зэрлэг адуу, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалахад шууд зориулагдана.

Таны хандив бидэнд ингэж тусалдаг – Танд маш их баярлалаа!

150,000 ТӨГРӨГ

Та 25 тахинд яаралтай тусламж болгон нэг өдөр тэжээх өвс нийлүүлнэ.

250,000 ТӨГРӨГ

Яаралтай тусламжийн өвс тэвэрлэх хуучин машин шуурхай худалдан авахад хувь нэмрээ оруулна.

300,000 ТӨГРӨГ

Та бүхний хувь нэмрээр ус хуримтлуулах чадвартай заган бутыг 1000 м2 талбайд нөхөн ургуулна.

600,000 ТӨГРӨГ

Та орон нутгийн 20 малчдад зориулсан бэлчээрийн менежмент, ноолуурын хоршооны менежментийн нэг сарын сургалтыг санхүүжүүлнэ.

Таны ямар ч хэмжээний хандив, Төв Азийн тал хээрийн энэхүү өвөрмөц зэрлэг амьтан, ургамлын аймаг төрөл зүйлийг хадгалан хамгаалахад тусалдаг.

Мандалын сүрэг, 2022 оны 12 сарын 21
Зургийг: С.Далайцэрэн

Биднийг Facebook Instagram-аар дагаарай



Тахийн унага үрчлээрэй! 300,000 төгрөг

Та “Тахийн найз нөхөд” болох уу?

- Хувь хүний гишүүнчлэлийн жилийн хураамж **130,000 төгрөг**
- Оюутан, залууст зориулсан “Унага” гишүүний хураамж **50,000 төгрөг**

Хандивын данс

Олон Улсын Тахь Группийн Монгол дахь товчоо
ХХБ 499114883 ам. долл.
499248691 төгрөг



Эрхлэн гаргасан
Freunde des Wildpferdes
c/o Stiftung Wildnispark Zürich
Alte Sihlstrasse 38
CH-8135 Sihlwald / ZH
www.savethewildhorse.org
info@savethewildhorse.org
itg.ulaanbaatar@gmail.com

Байгаль орчинд ээлтэй цаасан дээр хэвлэв. FSC
(Ойн Удирдах Зөвлөл) / EХ Эко шошгоны цаас

